



“СМАРТ ЭКО ТРАНС” ХХК

**АВТОМАТ УДИРДЛАГАТАЙ ЧИНГЭЛЭГ ТЭЭВРИЙН ТЕРМИНАЛ
БАЙГУУЛАХ ТӨСӨЛ**

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНБОГД СУМЫН
ГАСУУНСУХАЙТ ХИЛИЙН БООМТОД ҮЙЛ
АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ “СМАРТ ЭКО ТРАНС”
ХХК-ИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**



АГУУЛГА

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА 3
2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ
 - 2.1. Газарзүйн мужлал.....
 - 2.2. Уур амьсгал
 - 2.3. Агаарын чанар
 - 2.4. Гадаргын үс
 - 2.5. Газрын доорх үс
 - 2.6. Хөрс
 - 2.7. Ургамал
 - 2.8. Амьтан
 - 2.9. Газар ашиглалт
 - 2.10. Нийгэм, эдийн засгийн байдал
3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ
 - 3.1. Төслийн гол зорилт
 - 3.2. Цар хүрээ, хэмжээ
 - 3.3. Төсөл захиалагч байгууллагын хаяг
 - 3.4. Төслийн байршил
 - 3.5. Төсөл хэрэгжсэнээр
4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ
 - 4.1. Төслийн гол зорилт
 - 4.2. Цар хүрээ, хэмжээ
 - 4.3. Төслийн захиалагч байгууллагын хаяг
 - 4.4. Төслийн байршил
 - 4.5. Төсөл хэрэгжсэнээр
5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө
6. Орчны тохижилт цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө
7. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө
8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр
9. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө
10. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлганах төлөвлөгөө
11. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө
12. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө


1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Төслийн үйл ажиллагаа явуулж буй газрын засаг захиргааны харьяалал.

Ханбогд сум нь аймгийн төвөөс 260 км зайтай, засаг захиргааны анхан шатны нэгж болсон Номгон, Гавилууд, Жавхлант, Баян, Хайрхан гэсэн 5 багтай. 2021 оны жилийн эцсийн байдлаар Ханбогд сум нь 2116 өрхтэй, 8404 хүн амтай ба үүнээс төсөл хэрэгжих талбай байрлаж буй Номгон баг нь 1201 хүн амтай, 325 өрхтэй. Төслийн талбай нь улсын тусгай хамгаалалттай газар нутаг болон хилийн боомт орчимд байрлах тул хүн амын нягтшил багатай, эргэн тойронд малчин айл өрх байхгүй бөгөөд талбайгаас хойшоо буюу багийн нутаг дэвсгэрт тархмал байдлаар суурьшина.

Төслийн байршил: Автомат удирдлагатай чингэлэг тээврийн терминал байгуулах талбай нь Өмнөговь аймгийн Ханбогд сумын Номгон 1-р багийн нутаг дэвсгэрт Гашуунсухайтын хилийн боомтод оршино.

Зураг 1. Смарт эко транс ХХК-ийн “Автомат удирдлагатай терминал чингэлэг тээврийн терминалын талбайн байршил



Хүснэгт 1. Смарт эко транс (ХХК)-ийн мэдээлэл

Автомат удирдлагатай чингэлэг тээврийн терминал байгуулах төслийг хэрэгжүүлэгч аж ахуй нэгжийн нэр	Аж ахуй нэгжийн улсын бүртгэлийн дугаар	Үйл ажиллагааны чиглэл	Смарт эко транс ХХК-ийн хаяг, байршил
Смарт эко транс (ХХК)	6777678		

Хүснэгт 2. “Смарт эко транс” ХХК-ийн холбогдох албан тушаалтнуудын мэдээлэл

№	Нэр	Албан тушаал
1	Б.Батнасан	Смарт эко транс ХХК-ийн Гүйцэтгэх захирал



2	Тэнүүн	Смарт эко транс ХХК-ийн менежер
3	Ж.Майра	Смарт эко транс ХХК-ийн Байгаль орчны мэргэжилтэн

Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого Алсын хараа 2050-д үндэсний тээвэр, логистикийн тогтолцоог хөгжүүлэх, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.1.6-д нүүрс, бусад уул, уурхайн бүтээгдэхүүний экспортыг эрчимжүүлэх хүрээнд “Ногоон гарц” түр журмыг хэрэгжүүлэх, худалдааны түнш орнуудтай эдийн засгийн хамтын ажиллагааг идэвхжүүлэх экспортыг нэмэгдүүлэх, 3.1.18-д хилийн боомтуудын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлж, хөрш орнуудын хилийн боомтуудын жишигт хүргэх, Шинэ сэргэлтийн бодлогын 1.1-д боомтуудын хатуу зөөлөн дэд бүтцийг хөгжүүлэн ачаа болон зорчигч нэвтрүүлэх хүчин чадлыг дээшлүүлж, экспортыг нэмэгдүүлэх, 1.2-д хилийн боомтуудыг төмөр зам болон хатуу хучилттай авто замаар

үе шаттайгаар бүрэн холбон, тээвэр логистикийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэн ачаа тээврийн урсгалыг сайжруулж, цаашид транзит улс болох суурь нөхцөлийг бүрдүүлэхээр тусгасан.

2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

- 2.1. **Газарзүйн мужлал:** Төслийн талбай нь физик газарзүйн мужлалаар Говийн их болон Дорнод говийн мужийн Сулинхээр-Замын Үүдийн талархаг тойрогт хамаарах ба Байгалийн бүс бүслүүрээр Цөлийн бүсийн Жинхэнэ цөлийн бүслүүрт хамрагдаж байна. Нутаг дэвсгэрийн ерөнхий шинж нь нам уулс, жижиг толгод бүхий гүвээрхэг, долгиорхог өргөн тал хөндийн ерөнхий шинжийг хадгална.
- 2.2. **Уур амьсгал:** Уур амьсгалын мужлалын хувьд ерөнхийдөө гандуу дулаан зун, хүйтэн өвөлтэй, өвөл зуны температурын ялгаа ихтэй, хур тунадасны хувьд бага, татруу уур амьсгалтай. Зуны улиралд халуун хуурай, өвлийн улиралд дулаан, хавар болон намрын улиралд шороон болон цасан шуургатай өдөр олон тохиолдоно. Ханбогд сумын нутагт нарны нийлбэр цацрагийн жилийн дундаж 1500 квт ц/м²-аас их, нарны гийгүүллийн үргэлжлэх хугацаа жилд дунджаар 3400 цагаас их, сард 283 цагаас их, хоногт 11.8 цагаас их байдаг байна. Судалгаанд хамрагдаж буй газар нутгаар агаарын температурын олон жилийн дундаж 7.4⁰C болно. Жилд дунджаар нэн халуун буюу агаарын температур 30⁰C-ээс дээш өдрийн тоо 42 өдөр ажиглагдах на. Хөрсний өнгөн давхаргын жилийн дундаж температур 8.8⁰C байдаг ба зөвхөн өвлийн саруудад тэг градусас доошилдог.
- 2.3. **Агаарын чанар:** Өмнөговь аймаг нь хур тунадас бага, хуурай уур амьсгалтай нутаг бөгөөд сүүлийн жилүүдэд тус аймагт уул уурхайн салбар эрчимтэй хөгжихийн хирээр тоосжилт ихээр бий болж байгаа бөгөөд энэ нь уурхайн үйл ажиллагаа, тээвэрлэлтийн замуудтай шууд холбоотой гэж үздэг. Мөн сүүлийн жилүүдэд аймгийн нийт нутгаар хур бороо хомс, өвс ургамлын гарц муу байсан нь хөрс ихээр хуурайшиж тоос босох нэг нөхцөл болж байна.
- 2.4. **Гадаргын ус:** Ус зүйн мужлалаар Төв Азийн гадагш урсацгүй ай савын түр урсгал бүхий гол горхины мужид хамаарах ба гадаргын усны сүлжээ муу хөгжсөн, байнгын урсацтай гол горхи байхгүйгээс ус зүйн хувьд төдийлөн сайн судлагдаагүй. Монгол орны усны сав газраар Галба-Өөш Долоодын говь гэсэн ай савд хамаарагдана. Энэ бүс нутгийн олон жилийн дундаж урсац буюу модуль нь км²-д 0.5-0.1 л/с. Гадаргын урсац 5 мм, газар нутгийн нийт чийгшил 50-100 мм, голын сүлжээний нягтшил 0.01-0.05 км/км², гол мөрний нийлбэр урсац 0.5-1 л/с-км², усны гадаргаас уурших ууршилт 5-9 дугаар сард 900-1100 мм байна.
- 2.5. **Газрын доорх ус:** Өмнийн говийн тал болон хагас цөлөрхөг хуурай уур амьсгалтай геологийн нийлмэл тогтоцтой, ан цав багатай дүүрэг нь газар доорх ус бүрэлдэх хангалттай нөхцөл болж чаддаггүй тул газар доорх усны олон тооны жижиг бассейн, линз, давхаргууд үүсгэдэг бөгөөд давсархаг эсвэл давст устай байдаг. Төслийн талбай орчмын газрын доорх усны ашиглаж болох боломжит нөөцийн зургаас харахад бага нөөц баялагтай (0.03-0.3 л/с) нүх сүв, ан цавын чөлөөт болон дарагдмал

гадаргад ус тархсан ба газрын доорх усны нөхөн сэргээгдэх нөөц нь $< 5 \text{ мм/жил/км}^2$ бага байна.

- 2.6. **Хөрс:** Хөрс-газарзүйн мужлалаар Төв Азийн их мужийн Говийн мужийн өргөргийн бүсшилийн цөлийн бор саарал хөрсний Галбын говийн тойрогт хамрагдана. Нам уулс, толгодын хэсгээр дутуу хөгжилтэй сайр чулуурхаг цөлийн бор саарал (гөлтгөнөгүй), тал хөндий, нам хотос хэсгээр цөлийн бор саарал, цөлийн мараалаг бор саарал, уугуул хэлбэрийн мараа хөрс, элсэн хөрс голлон тархана.
- 2.7. **Ургамал:** Ургамал-газарзүйн мужлалаар Тал талархуу газрын Төв Азийн бүсийн Галбын говийн (цөлийн) тойрогт хамаарагдах бөгөөд бүхэлдээ жинхэнэ цөлийн хэв шинжийг илэрхийлэгч сөөг болон хагас сөөгөнцөр ургамал зонхилон тархсан.
- 2.8. **Амьтан:** Амьтны аймгийн газарзүйн мужлалын хувьд Умард говийн болон Алтайн өвөр говийн тойрогт хамаарах (А.Г.Банников 1954) бөгөөд говь цөлийн амьтад тэргүүлж мэрэгчдээс чичүүл, савагдаахай, загийн шар чичүүл, говийн алаг даага, бор зусаг, туурайтнаас хар сүүлт, хулан, янгир, аргаль, махчин амьтдаас чоно, үнэг зонхилно. Цөлийн экосистем тул амьдрах орчны элдэв хэв шинж цөөн илрэх бөгөөд бүхэлдээ нэг хэвийн амьдрах орчин зонхилох ба биологийн олон янз байдлын хувьд нэлээд ядмаг байдаг.
- 2.9. **Газар ашиглалт:** Өмнөговь аймгийн Ханбогд сумын 2022 оны газрын нэгдмэл сангийн тооллого, тоо бүртгэлээр сумын нийт газар нутгийн 77 хувь буюу 1,162,633.7 га талбайг хөдөө аж ахуйн газар, 13 хувь буюу 201,666.3 га талбайг улсын тусгай хэрэгцээний газар, 9 хувь буюу 132,924.0 га ойн сан бүхий газар түүний дотор заган ойгоор бүрхэгдсэн талбай, 0.6 хувь буюу 10,088.8 га талбайг зам, шугам сүлжээний газар, 0.3 хувь буюу 7028.2 га талбайг хот, тосгон бусад суурины газар, 0.1 хувь буюу 815 га талбайг усны сан бүхий газар тус тус эзэлж байна.
- 2.10. **Нийгэм, эдийн засгийн байдал:** Ханбогд сум нь аймгийн төвөөс 260 км зайтай, засаг захиргааны анхан шатны нэгж болсон Номгон, Гавилууд, Жавхлант, Баян, Хайрхан гэсэн 5 багтай. 2021 оны жилийн эцсийн байдлаар Ханбогд сум нь 2116 өрхтэй, 8404 хүн амтай ба үүнээс төсөл хэрэгжих талбай байрлаж буй Номгон баг нь 1201 хүн амтай, 325 өрхтэй. Төслийн талбай нь улсын тусгай хамгаалалттай газар нутаг болон хилийн боомт орчимд байрлах тул хүн амын нягтшил багатай, эргэн тойронд малчин айл өрх байхгүй бөгөөд талбайгаас хойшоо буюу багийн нутаг дэвсгэрт тархмал байдлаар суурьшина.

3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

3.1. Төслийн гол зорилт

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 09 дугаар сарын 14-ны өдрийн “Автомат удирдлагатай чингэлэг тээврийн терминал байгуулах тухай” 349 дугаар тогтоолоор КОВИД-19 цар тахлын үед экспортын хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор нүүрсний экспорт бүхий хилийн боомт, улсын хилийн бүс, зурвас газруудад автомат удирдлагатай чингэлэгт тээврийн терминал байгуулах, шаардлагатай хөрөнгө оруулалтыг нүүрс олборлон экспортолж буй аж ахуйн нэгжүүдийн санхүүжилтээр төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд гүйцэтгэхээр шийдвэрлэсэн байна.

Тус шийдвэрийн хүрээнд Автомат удирдлагатай чингэлэг тээврийн терминал байгуулахтай холбоотой санхүүжилтийн нийт зардлыг “Смарт эко транс” ХХК хариуцан санхүүжүүлэхээр тохиролцсон байна.

Уг төсөл нь Чингэлгийн тээврээр нүүрс тээвэрлэх, хадгалах, ачиж буулгах зэрэг үйл ажиллагаанд үүсэх хорогдлыг бууруулах, нүүрсний чанар алдагдуулахгүйгээр байгаль орчин, жолооч нарт ээлтэй, эдийн засгийн үр ашигтай экспортын хэмжээг нэмэгдүүлэх юм.

Ганц мод/Гашуунсухайт боомтын байгаль, орчны нөхцөлд нийцүүлэн, тухайн боомтын нүүрс тээвэрлэх үйл ажиллагаанд чиглэн, хоёр улсын холбогдох яамдын захиргааны шаардлагын дагуу аюулгүй, өндөр үр ашигтай, бага зардалтай нүүрсний хил нэвтрэх тээврийг зохион байгуулж, аюулгүй ажиллагаа болон хууль дүрэмд нийцүүлэн ачаа нэвтрэх үйл ажиллагааг зогсолтгүй сайжруулан, тээврийн бүтээмжийг нэмэгдүүлж, боломжит нөхцөлд 24 цагийн турш тасралтгүй тээвэр хийнэ.

3.2. Цар хүрээ, хэмжээ

Төслийн нэр: Автомат удирдлагатай чингэлэг тээврийн терминал байгуулах



Төслийн захиалагч байгууллага: “Смарт Эко Транс” ХХК

Төсөл хэрэгжүүлэгч, өмчлөгч байгууллага: Төр, хувийн хэвшлийн түншлэл

3.3. **Төсөл захиалагч байгууллагын хаяг:** Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 26-р хороо, Хүннүгийн гудамж-907, Их монгол оффис, Утас: 77410005, 80017879

3.4. **Төслийн байршил:** Автомат удирдлагатай чингэлэг тээврийн терминал байгуулах талбай нь Өмнөговь аймгийн Ханбогд сумын Номгон 1-р багийн нутаг дэвсгэрт Гашуунсухайтын хилийн боомтод оршино.

3.5. **Төсөл хэрэгжсэнээр:**

- Таван толгой бүлэг ордын хүрээнд үйл ажиллагаа эрхэлж байгаа тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдийн ачих нүүрс гүний гаалийн бүрдүүлэлт хийгдэж, нүүрстэй чингэлэг (нэгж чингэлэгт 32.5 тонн) ачсан тээврийн хэрэгсэл Гашуун сухайт боомт руу тээвэрлэх;
- Монгол талаас нүүрстэй чингэлэг (нэгж чингэлэгт 32.5 тонн) тээвэрлэгдэж ирээд гаалийн талбай дээр бууж, хоосон чингэлэг ачиж буцах;
- Хятад талаас өдрийн цагаар (08:00-20:00) хоосон чингэлэгтэй тээврийн хэрэгсэл нэвтэрч, нүүрстэй чингэлэг ачигдаж экспортод гарах;
- Давхар чиргүүлтэй нэг тээврийн хэрэгсэл нийт 4 нүүрстэй чингэлэг буюу 128 тонн нүүрс тээвэрлэх боломжтой;
- Давхар чиргүүлтэй 500 тээврийн хэрэгсэл гарах тохиолдолд өдөртөө 2,000 чингэлгээр нийт 64,000 тн экспортлох боломжтой;
- Гашуун сухайт боомт нь жилдээ 300 хоног ажиллахад 19.2 сая тонн нүүрс чингэлэг тээврээр экспортлогдоно гэж үзэж байна.

4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Смарт эко транс ХХК нь 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа 2023 онд Жэмр ХХК-ийн боловсруулсан Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангаар тодорхойлогдсон төсөл хэрэгжүүлэгчийн хүлээх үүрэг амлалтаас гадна Монгол Улсын Байгаль орчны багц хууль, холбогдох дүрэм журам, стандартуудын шаардлагуудыг биелүүлэхийг гол зорилгоо болгосон.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалын хавсралтын дагуу хийж гүйцэтгэв.

“Смарт эко транс” ХХК нь 2024 онд байгаль орчныг хамгаалах арга хэмжээнд нийт төгрөг зарцуулахаар төлөвлөлөө.

№	Хийгдэх ажлын чиглэл	Нийт зардал,
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	2,200,000
2	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	269,740,000
3	Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	1,000.000
4	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	1,800,000
5	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	2,500,000
6	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	634,000
7	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	2,100,000

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө-2024



8	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	Дотоод нөөц бололцоогоор
Нийт		279,974,000

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө-2024

5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
5.1	Машин техникийн түлшний дутуу шаталтаас бохирдуулагч хий ялгарах	Техникийн улсын үзлэгт тогтмол оруулах	Терминалын талбайд ажиллаж буй техник хэрэгсэл	ш	Үйл ажиллагааны зардалд тусгах			04 сар	MNS 5023:2013 MNS 5014:2013
5.2	Газрын доорх усны нөөц хомсдол, ус ашиглуулах дүгнэлтэд заасан хэмжээнээс хэтрүүлэн ашиглах	Усны тоолуур суурилуулах	Терминалын шинээр гаргах гүний худгууд	ш	600.000	2	1,200.00	01 сар	Усны тухай хууль
5.3		Тоолуурын баталгаажилт хийлгэх	Терминалын шинээр гаргах гүний худгууд	ш	50.000	2	100.000	01 сар	
5.4	Техник хэрэгсэл, ашигласан тос, тосолгооны материал асгарч хөрсийг бохирдуулах	Асгаралтын шингээгч бодис/ Spill kits/ нөөцөд бэлэн байлгах, шаардлагатай газруудад байршуулах	Засварын талбай, түлш цэнэглэх талбай	Ш	900,000	1	900,000	01	MNS5058:2019
	Нийт						2,200,000		

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө-2024

7. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

“Соёлын өв” гэж түүхэн тодорхой орон зай, цаг үеийн аль нэг хэсгийг төлөөлж чадах байгаль, нийгэм, түүх, соёл, урлаг, шинжлэх ухааны үнэ цэнэ, ач холбогдол бүхий түүхэн тодорхой орон зай, цаг үеийг төлөөлөх биетээр оршин байгаа дурсгал бүхий өвийг ойлгоно. Бид үйл ажиллагаа явуулж буй орон нутгийнхаа түүх, соёлын өвийг хамгаалахад хувь нэмрээ оруулах зорилгоор соёлын өвийн хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

№	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
7.1	Биет болон биет бус өв	Ажилчдад Соёлын өвийн зааварчилгаа өгөх, дурсгалт зүйлс олдох үед баримтлах сургалт, мэдээлэл танилцуулах	Төслийн талбайд ажиллах нийт ажилчид	Нийт ажилчид	Үйл ажиллагааны зардалд тусгах		Улирал бүр	Соёлын өвийг хамгаалах тухай хууль
7.2		Сум багийн биет бус соёлын өвийг хадгалах, хамгаалах, тал дээр тусламж үзүүлэх	Орон нутагт	-	1,000.000	1,000.000	2024 он	
	Нийт					1,000.000		

8. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
8.1	Осол гэмтэл, байгалийн гамшигт үзэгдэл, тоног төхөөрөмжийн саатал зэрэгт ажлагасад өртөх, хариу арга хэмжээ авч чадахгүйгээс үүдэн эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учрах	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, анхны тусламжийн сургалт зохион байгуулах	Төслийн талбайд ажиллагсад	4	Дотоод нөөц бололцоогоор		Сар бүр	

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө-2024

8.2	Нефтийн бүтээгдэхүүнтэй байнга харьцаж ажилладаг ажиллагсдын эрүүл мэндэд нөлөөлөх	XXX-ээр бүрэн хангах, эрүүл мэндийн үзлэгт жилд 1 удаа заавал хамруулах	Нийт ажилчид	1	1,500,000	Жилд 1	
8.3	Нефтийн бүтээгдэхүүнийг ачих, буулгах үед асгарах, шүүрэх зэргээр тухайн орчны хөрсийг бохирдуулах	Хэрэв асгаралт болсон тохиолдолд хоргүйжүүлэх, саармагжуулах арга хэмжээг нэн яаралтай авах	Нефтийн бүтээгдэхүүн ачих буулгах талбай	-	Дотоод нөөц бололцоогоор	2024	
8.4	Нефтийн бүтээгдэхүүнтэй харьцаж байгаа ажиллагсдад мэдлэг, дадлага туршлага хангалтгүй эсвэл анхаарал болгоомжгүйгээс ажлын хариуцлага алдах анхны тусламж үйлчилгээг мэдэхгүйн улмаас эрүүл мэндээр хохирох	Ажилчдад нефтийн бүтээгдэхүүний физик, химийн шинж чанар, тэдгээртэй ажиллах, хадгалах, тээвэрлэх үед мөрдөх аюулгүй ажиллагааны зохих мэдлэгийг эзэмшүүлэх сургалт, семинар тогтмол зохион байгуулах	Нийт ажилчид	1	300,000		
	Нийт				1,800,000		

9. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
9.1	Ахуйн	Орон нутагтай хог хаягдлын гэрээ байгуулах	Төслийн талбай	сар	20,000	12	240,000	2024	Хог хаягдлын тухай хууль
		Хог хаягдлыг нэг цэгт цуглуулан ангилж, зориулалтын дагуу хадгалан тогтмол хугацаанд тээвэрлүүлж байх	Төслийн талбай	Сар бүр	50,000	12	600,000	сар бүр	Өмнөговь аймгийн ИТХ-ын 2018 оны 4/16 тоот тогтоол, MNS 5850:2019
		Зам талбайн хийсэж тархсан хог хаягдлын цэвэрлэгээ зохион байгуулах	Төслийн талбай	Тоо	Дотоод үйл ажиллагаанд тусгах	12		Сар бүр	Хог хаягдлын тухай хууль

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө-2024



9.2	Үйлдвэрийн	Ажилчдын ахуйн хэрэглээнээс гарах бохир усыг хөрсөнд асгаж доройтуулахгүй байх, септик систем ашиглах	Офиссын цэвэрлэх байгууламж	Тонн	71,667	12	860,004	Cap	Хүрээлэн байгаа орчин Усны чанар Хаягдал ус. Ерөнхий шаардлага MNS 4943:2015
9.3	Аюултай	Засварын газар, машины зогсоол орчимд асгаралтын иж бүрдэл байршуулах	Туслан гүйцэтгэгч компаниуд	Ш	800,000	1	800,000	2024	Хөрс бохирдуулагч бодисын ЗДХ MNS 5850:2019
		Орон нутгаас хог хаягдлын код авах	Хог хаягдлын цэг болон өрөө тасалгаа	удаа		1		2024	“Эрүүл ахуйн тухай хууль” 7.4, “Хүнсний тухай хууль” 10.12
	Нийт						2,500,000		

10. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
	1	2	3	4	5	6	7	8
	Агаар							
10.1	Хүхрийн исэл SO ₂ Азотын давхар исэл NO ₂ Нүүрстөрөгчийн дутуу исэл CO Тоос PM 2.5 Тоос PM 10 Дуу чимээ	Терминалын талбай	Улиралд 1 удаа 3 цэгээс	4 удаа	17,500	210,000		Агаар мандлын сорьц авах ерөнхий шаардлага УСТ 3384-82 Агаар чанар MNS 4585:2016
Гадаргын болон газрын доорх ус								
10.2	Усны химийн найрлага, хүнд металлын агууламж бактериологи	Терминалын талбайн худаг	Улиралд 1 удаа	4 удаа	Усны шинжилгээний үнэ макрохими 20,000 Микрохими 20000	160,000		MNS 0900:2018 Ундны усны эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт
10.3	Органик бохирдол	Цэвэрлэх байгууламж	Улиралд 1 удаа	4удаа	Хаягдал ус 20,000	80,000		MNS 4943:2015 Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус
Хөрс, газрын гадарга								

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө-2024

10.4	Хөрсний хүнд метал (Cr, Cd, Pb, Ni, Cu, Zn)	Хогийн цэг, машины зогсоол	Улиралд 1 удаа	4 удаа	20,000	80,000	MNS 5850:2019 Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ
10.5	Хөрсний нянгийн бохирдол	Бие засах газар, хогийн цэг	Улиралд 1 удаа 2 цэгээс	4 удаа	13,000	104,000	MNS 3297:2019 Хөрс. Хот, суурин газрын хөрсний эрүүл ахуйн аюулгүйн үзүүлэлт, бохирдлыг үнэлэх
Нийт						634,000	

11. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			20.. он				
			Сар ...	Сар ...	Сар ...		
	1	2	3	4	5	6	7
11.1	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө ба түүний биелэлтийн тайланг боловсруулах	525,000	11 сар			Захиргаа удирдлагын алба	Төлөвлөгөөний дагуу хамаарах албан тушаалтан бүр тайлан гаргах
11.2	Байгаль орчны чиглэлээр шинийг санаачилсан цөөн тооны хүмүүсийг шагнаж урамшуулах	525,000			12 сар	Захиргааны мэргэжилтэн	

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө-2024



11.3	Байгаль орчны асуудал хариуцсан ажилтныг мэргэшүүлэх сургалтад хамруулах	525,000	.. сар			Хүний нөөц	Шаардлага тай сургалт зохион байгуулагдах хугацаанд
11.4	Ус ашиглах дүгнэлт гаргуулах	Дотоод нөөц бололцоогоор	04 сар			Захиргаа удирдлагын алба	Холбогдох албан тушаалтан бүр чиглэлийн дагуу оролцох
11.5	Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулан, баталж үйл ажиллагааны турш хэрэгжүүлэх	525,000				Захиргаа удирдлагын алба	Холбогдох албан тушаалтан бүр чиглэлийн дагуу оролцох
11.6	Ус ашиглах гэрээ орон нутагтай байгуулах	Дотоод нөөц бололцоогоор				Захиргаа удирдлагын алба	Усны тухай хууль
	Нийгмийн хариуцлагын хүрээнд орон нутагт цаг үед нь тохирсон тусламж дэмжлэг үзүүлэх	Цаг үеийн байдлаас шалтгаалж				Захиргаа удирдлагын алба	
	Нийт					2,100,000	

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө-2024



12. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

№	БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
	1	2	3	4	5	6	7
12.1	Өмнөговь аймгийн Даланзадгад суманд зохион байгуулагдах “Нээлттэй өдөрлөг”-т оролцож, 2024 онд Байгаль орчныг хамгаалах чиглэлээр хэрэгжүүлж байгаа арга хэмжээний танилцуулга хийнэ.	Нээлттэй өдөрлөгт оролцох	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээнүүдийн хэрэгжилт, ашиглаж буй багаж, тоног төхөөрөмжийн тухай дэлгэрэнгүй мэдээлэл өгөх	Хугацааны тов тодорхойгүй	Дотоод ажиллагааны зардалд тусгах	Захиргаа удирдлагын алба	Өмнөговь аймгийн Даланзадгад хот
12.2	2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг БОАЖГ-т хүргүүлэх, танилцуулах, дүгнүүлэх, БОАЖЯ-аар батлуулах	Цахимаар	Хэрэгжүүлсэн ажлыг дүгнэх	2024.11.01-ээс өмнө	Үйл ажиллагааны зардалд тусгах	Үйл ажиллагааны менежер	Улаанбаатар хот
12.3	2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг БОАЖЯ-аар батлуулах	Цахимаар	Үйл ажиллагаанд удирдлага болгон ажиллах	2024.12. багтаах	Үйл ажиллагааны зардалд тусгах	Байгаль орчны мэргэжилтэн	Улаанбаатар хот
12.4	Өмнөговь аймгийн Ханбогд Хайрхан багийн иргэдэд үйл ажиллагааг танилцуулж мэдээлэл хүргэх өдөрлөг зохион байгуулах.	Өдөрлөг зохион байгуулах	Багийн иргэдтэй санал хүсэлт солилцох	Хугацааны тов тодорхойгүй	Дотоод нөөц бололцоогоор	Захиргаа удирдлагын хэлтэс	Өмнөговь аймгийн Хайрхан баг
	Нийт						

